



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/339

Хэрлэн сум

Халдварт өвчин тархахаас
урьдчилан сэргийлэх зорилгоор зарим сумдад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн онцгой комиссын 2024 оны 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмээс хүн, малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим сумдад 100.000.000 (нэг зуун сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах тооцоог хавсралтаар баталсугай.

3.Мал, амьтны мэг зэм устгалын ажлыг дуусгах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д даалгасугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Улсын Онцгой комиссоос малын сэг, зэм устгахад зориулж ирүүлсэн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
...дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах тооцоо

д/д	Сумын нэр	Мөнгөн дүн /сая/
1	Баян-Овоо	5.000.000
2	Өмнөдэлгэр	5.000.000
3	Дэлгэрхаан	3.000.000
4	Баянмөнх	5.000.000
5	Дархан	5.000.000
6	Галшар	17.100.000
7	Баянхутаг	5.000.000
8	Онцгой байдлын газар	20.000.000
9	Малын сэг, зэм устгах ажлын үед зарим сумдад үүссэн өглөгийг барагдуулах	34.900.000
	Нийт	100.000.000